

БАТЛАВ
“ДЦС-4” ТӨХК-ийн ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

БАТЛАВ
“ЭВСЭЛ ЭРЧ ХҮЧ” ХХК-ийн
ЗАХИРАЛ

ХАЯГДАЛ ТӨМӨР ХУДАЛДАХ ГЭРЭЭ

2021 он 05 дугаар сарын 10-ны өдөр

№ 4/2021-189 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “ДЦС-4” ТӨХК-г төлөөлж БҮЭД захирал Б.Сандуйжав /цаашид худалдагч гэх/ нөгөө талаас “ЭВСЭЛ ЭРЧ ХҮЧ” ХХК-ний захирал Ж.Пүрэвсүх цаашид худалдан авагч гэх/ нар нь Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, 31 дүгээр зүйлийн 31.2 дэх заалтуудыг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь “ЭВСЭЛ ЭРЧ ХҮЧ” ХХК-ний хаягдал төмөр худалдан авахад ачих, тээвэрлэх, жинлэх нөхцлийг хангах ба тээврийн хэрэгсэлийг орж гарахад хяналт тавих төлбөрийг цаг хугацаанд нь гэрээнд заасны дагуу төлөх, гэрээт хугацаа эхлэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажсанаар гэрээ хууль зүйн хүчин төгөлдөр болж, худалдах худалдан авах ажиллагаа эхлэнэ.
- 2.2 Худалдах ба худалдан авах ажиллагаа нь 2021 оны 05-р сарын 10-наас 2021 оны 08-р сарын 10-ний өдөр хүртэл хугацаатай явагдана.
- 2.3 Хоёр тал харилцан тохиролцсны үндсэн дээр гэрээний гүйцэтгэлийн хугацааг сунгаж болно.

Гурав. Төлбөр тооцоо

- 3.1 Хаягдал төмрийг ялгаж сорчлохгүйгээр бөөнд нь нэг тонн-ийг 242000 төгрөг, хаягдал ширмийг нэг тонн-ийг 165 төгрөг, хаягдал труба ф300 дээш нэг тонн-ийг 440 төгрөг байхаар, хаягдал труба ф300 доош нэг тонн-ийг 308 төгрөг байхаар талууд харилцан тохиролцов. Энэ үнэнд НӨАТ шингэсэн болно.
- 3.2 Худалдан авагч нь дунджаар өдөрт 1-2 машин хаягдал төмөр ачиж гаргана. Энэ нь тухайн өдрийн ачилтын хэмжээнээс хамаарч хэлбэлзэж болно.
- 3.3 Хаягдал төмөр, ширэм, трубаны хорогдлыг “ДЦС-4” ТӨХК-ийн хорогдол тооцох журмын дагуу тухай бүрд нь тооцно
- 3.4 Хаягдал төмөр ачих машинаа баталгаатай авто пүүнд жинлүүлэн, төлбөрийг тухай бүрд нь ДЦС-4 ТӨХК-н кассанд төлж зөвшөөрлийн бичиг авна

Дөрөв. Худалдан авагчийн үүрэг

- 4.1 Худалдан авагч нь ДЦС-4 ТӨХК-нд дараахь дугаартай тээврийн хэрэгсэлийг нэвтрүүлнэ Үүн: 28-94 УАМ, 13-06 УБЯ, 38-57 УНИ, 24-41 УБИ Тээврийн хэрэгсэлийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана. Замын хөдөлгөөний дүрмийг чанд сахиж ажиллана.
- 4.2 Худалдан авагч нь харуулын постоор зөвшөөрлийн дагуу орж, гарахдаа станцын нутаг дэвсгэрт дотоод журмыг мөрдөнө.
- 4.3 Худалдан авагч нь боруулалтын мэргэжилтний зааж өгсөн хаягдал төмрийг ачих үүрэгтэй бөгөөд дур мэдэн ачилт хийхгүй байх
- 4.4 Худалдан авагч нь ачилт хийж дууссны дараа хоёрдогч түүхий эд хашаа цэвэрлэж өөрсдийн зардлаар хог хаягдлын тээвэрлэнэ.

Тав. Худалдагчийн үүрэг

худалдагч :

худалдан авагч:

- 5.1 Худалдагч нь худалдан авагч талын харуулаар орох гарахад хяналт тавьж хаягдал төмөр авах нөхцлийг хангаж ажиллана.
- 5.2 Станцын БМА-ны борлуулалтын мэргэжилтэн ачилтанд тогтмол хяналт тавьж ачилтыг зохион байгуулна
- 5.3 Харуулын постоор нэвтрэх тээврийн хэрэгсэл, ажиллах хүчний зөвшөөрлийг хууль журмын дагуу хүндрэл чирэгдэлгүй шуурхай зохион байгуулах .

Зургаа. Хоёр талын эрх

- 6.1 Гэрээнд заасны дагуу худалдан авах ажиллагаанд хоёр талын эрх бүхий хүмүүс тухай бүр нь хянаж баталгаажуулж байна.
- 6.2 Гэрээнд зааснаас өөр үйлдэл хийх буюу эд зүйлийг эвдсэн, хулгайлсан, архи уусан зэрэг бусад хэв журмын зөрчил гаргасан тохилдолд гэрээг цуцлах эрхтэй.
- 6.3 Техник Хяналтын Хэлтсийн шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, эсэргүүцсэн тохиолдолд гэрээг цуцлуулах хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Худалдагч талыг төлөөлж:

Худалдан авагч талыг төлөөлж:

“ДЦС-4” ТӨХК-ИЙН ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ
БӨГӨӨД ГЭРЭЭНИЙ ИНЖЕНЕР

..... Б.ГАНХУЯГ
/2021 ОН 5 САР 10 ӨДӨР/

“ЭВСЭЛ ЭРЧ ХҮЧ” ТӨХК- ИЙН
МЕНЕЖЕР Г.ЛХАГВА-ЭРДЭНЭ

.....
2021 ОНЫ.....САРЫН.....ӨДӨР

ЗАХИРАЛ..... Б.САНДУЙЖАВ
/2021 ОН ...САР...ӨДӨР/

“ДЦС-4” ТӨХК-ИЙН
БМА-НЫ ДАРГА

..... С.АЛТАНХУЯГ
/2021 ОН 5 САРЫН 10 ӨДӨР/

“ДЦС-4” ТӨХК-НИЙ
СБА-ИЙН ДАРГА

..... Д.ТӨМӨРТОГОО
/2021 ОН 5 САРЫН 10 ӨДӨР/

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

..... Ч.БЯМБАСҮРЭН
/2021 ОН...САРЫН...ӨДӨР/

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

..... С.ДОНИД
/2021 ОН 5 САРЫН 10 ӨДӨР/

ХОЁР ТАЛЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ

Монгол улс,
16100 Улаанбаатар хот
Баянгол дүүрэг, 20 дугаар хороо
“ДЦС-4” ТӨХК
Утас: 70170783
ДАНС: ДЦС- 4 ТӨХК КАСС

Худалдан авагчийн хууль ёсны хаяг, утас, факс,
СХД -ийн 16-р хороо өнөр хороолол 25/205 тоот
Утас №88177751:

худалдагч :

худалдан авагч:

